



ӨМНӨГОВЬ АЙМАГ
НОМГОН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 25

Сангийндалай

Тэргүүлэгчдэд урамшуулал олгох
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 20 дугаар зүйлийн 20.1.1, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 94 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Номгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг мөрдөн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд, хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Булгамаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү шийдвэр гарсантай холбогдуулан 2010 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн 35 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.АДЪЯАБАТ